



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/256.

Мандалговь

“Дундговь түншлэл-2020” үзэсгэлэн,
худалдаа зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а”, 30 дугаар зүйлийн 30.1.3, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.2.7, Аймгийн үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хүн амын хүнсний болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хангамжийг дотоодын үйлдвэрлэлээр хангах өргөн боломжийг бүрдүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлж стандартын шаардлага хангасан үйлдвэрлэлийн боловсруулах түвшинг ахиулах, харилцан туршлага солилцох түншлэл тогтоох, үйлдвэрлэл үйлчилгээг сурталчлах зорилгоор “Дундговь түншлэл-2020” үзэсгэлэн худалдааг 2020 оны 9 дүгээр сарын 27-ний өдөр “Чагдаржав”-ын талбайд зохион байгуулсугай.

Хоёр. “Дундговь түншлэл-2020” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. “Дундговь түншлэл-2020” үзэсгэлэн худалдаанд оролцсон байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шалгаруулах номинаци, шалгуур үзүүлэлтийг гаргаж, нийт сумд, байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

Дөрөв. Үзэсгэлэн худалдааны шагналд шаардлагатай 2.250.000 (Хоёр сая хоёр зуун тавин мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг)-д тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О БАТ-ЭРДЭНЭ



483019718

Аймгийн Засаг даргын 2020 оны 09..
дүгээр сарын 25...ны өдрийн 4/256 тоот
захирамжийн нэгдүгээр хавсралт

“Дундговь түншлэл-2020” үзэсгэлэн худалдааг
зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга: Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн
бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд: О.Мөнхзул (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн мэргэжилтэн)

Б.Ууганцэрэн (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Э.Одончимэг (Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын
хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Мөнхжаргал (Хүнс, хөдөө, аж ахуйн газрын дарга)

Г.Хишигдаваа (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын
дарга)

А.Пүрэвсүрэн (Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн дарга)

Б.Цэрэнханд (Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэрлэл,
худалдаа үйлчилгээний албаны дарга)

Ж.Мөнхбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Э.Эрдэнэтунгалаг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Д.Дэнсмаа (Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн
мэргэжилтэн)

Ж.Зоригтбаатар (Ажил олгогч эздийн холбооны салбарын
тэргүүн)

Нарийн бичгийн дарга: Д.Энхтуяа (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2020 оны ...
дүгээр сарын ...-ны өдрийн ...-оор
захирамжийн хоёрдугаар хавсралт

“Дундговь түншлэл-2020” үзэсгэлэн худалдааны
шагналын зардлын жагсаалт

№	Зардлын нэр	Х/н	Тоо хэмжээ	Үнэ		Зардал хариуцах байгууллага
				Нэг бүрийн	бүгд	
Засаг даргын нөөц сангаас шагнагдах шагналууд						
1	Шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц
2	Шилдэг газар тариалангийн бүтээгдэхүүн	ш	1	150,000	150,000	Засаг даргын нөөц
3	Шилдэг Хүнсний бусад нэрийн бүтээгдэхүүн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц
4	Шилдэг Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц
5	Шилдэг гар урлалын болон бэлэг дурсгалын бүтээгдэхүүн	ш	2	150,000	150,000	Засаг даргын нөөц
6	Шинэ бүтээгдэхүүн, шинийг эрэлхийлэгч аж ахуйн нэгж, иргэн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц
7	Нийтийн хоолны салбарын шилдэг үйлдвэрлэгч байгууллага	ш	1	150,000	150,000	Засаг даргын нөөц
8	Аймгийн брэнд бүтээгдэхүүн	Ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц
9	Хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн	ш	1	150,000	150,000	Засаг даргын нөөц
ДҮН			15		2,250,000	